БАТЛАВ
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ӨНДӨРХААН-ЧОЙБАЛСАН ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМЫН 271-298 КМ ХООРОНДОХ 27 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ИХ ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТИЙН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ (ДОРНОД, БУЛГАН СУМ) БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2023 оны 04 сарын 10 -ны өдөр № А33Т-06/23 Улаанбаатар хот

1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 2-р хавсралт, Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/16 дугаар тушаал
2. Байршил	Дорнод аймгийн Булган сумын нутаг дэвсгэрт
3. Замын эхлэлийн цэг	А0502 дугаартай Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто зам 271км орчимд эхлэх цэг (Захиалагчтай зөвшилцөнө)
4. Замын төгсгөлийн цэг	А0502 дугаартай Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто зам 298км орчимд төгсгөл цэг (Захиалагчтай зөвшилцөнө)
5. Замын хучлага	Асфальтбетон
6. Хучилтын бүтээц	Тооцоогоор
7. Төсөллөлтийн норм	• "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016 • "Хот суурины гудамж зам төлөвлөлт" БНбД 32-01-04 • "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" АЗУАГН 2.01.01-2004 • "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" БНбД 22.01.01*/2006 • "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил" БНбД 3.01.03-88 • "Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" MNS4597:2014 • "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" MNS4596:2014 • "Тахир дутуу иргэдэд зориулсан

	барилгын төлөвлөлтийн нормаль /БД 31-101-04/ барилгын дүрэм • “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009 • Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598: 2020 • Бусад шаардлагатай Монгол улсын холбогдох ЗЗБНбД, БНбД болон стандартуудыг хатуу баримтлан, тэдгээрт бүрэн нийцүүлэн гүйцэтгэнэ.
6. Зураг төсөл зохиох үе шат, дуусгах хугацаа	1 үе шаттай, 2023 оны 3 дугаар улиралд багтаана.
7. Зураг төслийн иж бүрдэл	Дараах хэсгүүдийг нэгтгэсэн Авто замын засварын ажлын иж бүрэн зураг төсөл: • Замын нийт уртад техник ашиглалтын түвшний судалгаа, далан, сууринд ашигласан материалын судалгааны дүн, замын эвдрэлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт • “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНбД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил” БНбД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу боловсруулсан байр зүйн хэмжилтийн ажлын тайлан • Үр дүнд суурилсан засварын ажлын техникийн шаардлага • Дараах хэсгүүдийг нэгтгэсэн Авто замын ажлын иж бүрэн зураг төсөл: • Тухайн замыг барьж бүрэн дуусгахад шаардлагатай (тухайлбал, нийтийн тээвэрт зориулсан түр зам, газрын өнгөн хөрс хуулах, ус өнгөрүүлэх хоолой ба ус зайлуулах бусад байгууламж, гүүр, ул хөрс солих, цэвдгийг гэсэлтээс хамгаалахад зориулсан дулаан тусгаарлах ба чулуун асгаасан үе, шороон далан, ухмал, далангийн дээд үе, тусгай үеүд, суурийн дэвсгэр үе, замын суурь ба хучлага, ан амьтныг хөндлөн гаргах байгууламж, замын тоноглол, бетон барьер, хөдөлгөөн зохицуулалтын ба аюулгүй байдлын хэрэгслүүд, тэмдэг ба тэмдэглэл, зогсоол ба амрах талбай, зам, гүүрийн барилгын зурваст орсон шилэн кабелийг хамгаалах, цас хунгарлалтыг багасгах хэрэгсэл зэрэг) бүх төрлийн ажлын (гэхдээ эдгээрээр

	зөвхөн хязгаарлагдахгүй) нарийвчилсан зураг, • Зурагт тусгагдсан бүх ажлын техникийн шаардлага (ТШ), • Мөн зурагт тусгагдсан бүх төрлийн ажлын болон Барилгын нийт ажлын тоо хэмжээний жагсаалт (АТХЖ), • Замын өртгийн Инженерийн нарийвчилсан тооцоо (ИНТ), • Инженерийн дэлгэрэнгүй тайлан (ИДТ), • Байр зүйн судалгааны болон геодезийн хэмжилтийн ажлын дэлгэрэнгүй тайлан, • Геоморфолог, гидрогеолог, геотехникийн болон материалын олдоцын судалгааны дэлгэрэнгүй тайлан • Гадаргуугийн усны ба цаг уурын судалгааны дэлгэрэнгүй тайлангаас бүрдэнэ. • Зам, гүүрийн зурваст орсон инженерийн байгууламж, цахилгаан, холбоо, дулаан, шилэн кабелийн шугам сүлжээний зураг төсөл, техникийн нөхцөлийг холбогдох байгууллагуудаас авах, авто замын трасст орсон иргэн аж ахуй нэгжийн газар чөлөөлөх (газар, обьект), нүүлгэн шилжүүлэх ажлын судалгаа гаргах, ажлын тоо хэмжээ, зардал; • Ажил гүйцэтгэх аргачлал • Хучилтын тооцоо • Ус зайлуулах байгууламжийн тооцоо • Хөдөлгөөний аюулгүй байдлын дүгнэлт • Замын их засвар, шинэчлэлтийн ажилтай холбоотой шороон орд, материал ашиглах газар олгосон орон нутгийн засаг захиргааны захирамж болон бусад зөвшөөрөл • Зураг төслийн иж бүрдэл тус бүрийг баталгаажуулсан Магадлалын ерөнхий дүгнэлт
8. Зураг төслийн байгууллага	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” Монгол Улсын хуулийн дагуу сонгогдон шалгарсан хуулийн этгээд
9. Захиалагч байгууллага	Зам, тээврийн хөгжлийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам

10. Онцгой нөхцөл

- Замын шинэчлэх хэсгийн техник ашиглалтын судалгааны дагуу асфальтбетон замын далан ба суурийн үеийн даац (CBR)-ыг тодорхойлж, шаардлага хангаагүй тохиолдолд далангийн дээд үе ба суурийг солихоор зураг төсөлд тусгах;
- Зам, тээврийн хөгжлийн яамны Замын ашиглалт, засварын хэлтэстэй засварын төрөл, хучилтын хийцийг танилцуулж, зөвшилцөх;
- Замын эхлэл, төгсгөлийн цэгийг Захиалагч байгууллагатай зөвшилцөж, авто замын салбарын Шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, зөвлөмж гаргана.
- Ус зайлуулах байгууламжид судалгаа хийж, шаардлагатай газар усны тооцоо хийж, хиймэл байгууламжийн нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, хийц, засварыг нэмж төлөвлөх;
- Их засвар хийгдэж байгаа авто замд Зам хариуцагч байгууллагаас холбогдох мэдээллийг авч зураг төсөлд тусгах;
- Их засвар хийгдэж байгаа замд орон нутгийн замын цагдаагийн газраас гаргасан авто тээврийн хэрэгслийн ослын судалгааны дагуу үзэгдэх орчин хязгаарлагдсан хэсэгт замын далан, хучилтыг өргөсгөх, эргэлтийн радиусыг нэмэгдүүлэх тооцоог хийж, зураг төсөлд тусгах;
- Хуучин хучилтыг газар дээр нь дахин боловсруулах аргаар эргүүлэн ашиглах боломжийг судалж, зураг төсөлд тусгах;
- Одоо байгаа замын даланг ашиглах, ухмалыг шаардлагатай хэмжээнд хүртэл өргөсгөх, тээврийн хэрэгсэл түр зогсох, зорчигч саатах зогсоол байгуулах, шаардлага хангасан материалыг ашиглахаар зураг төсөлд тусгах;
- Хучилтын бүтээцийг ЗТБХБСайдын 2010 оны 313 дугаар тушаалаар батлагдсан "Монгол орны асфальтбетон хучлагатай авто замын хучилтын хийцийн жишиг цомог"-ийг жишиг болгох;
- Уулзвар, орц гарцын хөдөлгөөний аюулгүй байдлыг дахин нягталж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн зураг төсөлд тусгах;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан хийц, тэмдэг тэмдэглэгээ, тоноглолыг оновчтой төлөвлөх;
- Үр дүнд суурилсан засварын ажлын

техникийн шаардлага боловсруулах;

- Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөвт тусгах;
- Замын хөдөлгөөн зохион байгуулалт, тоноглолын зураг төслийг нарийвчлан боловсруулж, хөдөлгөөний аюулгүй байдлыг аудит хийлгэх;
- Төсөллөлтийг гүйцэтгэхдээ шаардлагатай тохиолдолд Захиалагчтай зөвлөлдөж, Инженерийн нарийвчилсан зураг боловсруулахтай холбогдолтой бүх асуудлыг энэхүү даалгаврын Хавсралт № 1-д тусгасан жишиг бүтцийн дагуу Инженерийн дэлгэрэнгүй тайлан (ИДТ)-д бүрэн тусгана. Тухайн газар орны газрын гадаргуугийн зураг, үндсэн реперийн сүлжээ, элемент тус бүрийн төсөллөлтөд ашигласан шалгуур үзүүлэлтүүд, анхны төсөөлөл, загвар, хэрэглэсэн арга, тооцооллын хураангуй, материалын туршилтын үр дүн зэргийг хамруулан, цуглуулсан бүх өгөгдлийг ИДТ-д хавсралт болгон тусгана.
- Зөвлөх нь бүх өгөгдөл, инженерийн нарийвчилсан зураг, баримт бичгийн үнэн зөв, иж бүрдлийг бүрэн хариуцах бөгөөд шаардлагатай бол барилгын ажлын тендер шалгаруулалтын үед зохих тодруулгыг өгнө.
- Зургийн байгууллага хариуцлагын даатгалд хамрагдсан байх;
- Их засварын зураг төслийн иж бүрдлийг Захиалагчаар хянуулж, зөвшилцсөний дараа магадлалд оруулна.

Хянасан:

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.БОЛОР-ЭРДЭНЭ

Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга Ч.СУГАРМАА

Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ахлах шинжээч

Д.ЗАГДРАДНАА

Боловсруулсан:

Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Шинжээч

Б.ЦЭРЭНСОДНОМ

хавсралт № 1

ИНЖЕНЕРИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

1. ЕРӨНХИЙ ТОЙМ
2. ҮНДЭСЛЭЛ (Зураг төслийг боловсруулах болсон)
3. ЗАХИАЛАГЧ
4. ЗҮ-НИЙ ГЭРЭЭ
5. АЖЛЫН ДААЛГАВАР
6. ЗАМ БАРИЛГЫН АЖИЛТАЙ ХОЛБОГДОЛТОЙ ГАЗАР ОЛГОЛТЫН ТАЛААРХ ЗАХИРАМЖ, ШИЙДВЭР, ЗӨВШӨӨРӨЛ
7. ХОЛБОГДОХ ГАЗРУУДААС ОЛГОСОН ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ
8. ЗАХИАЛАГЧААС ХАНГАСАН ӨГӨГДӨЛ
9. СОНГОСОН ТРАССЫН ДАГУУД ХИЙСЭН ХЭЭРИЙН ХАЙГУУЛ, СУДАЛГАА
   - Геоморфологийн,
   - Гидрогеологийн,
   - Байр зүйн,
   - Геоинженерийн болон материалын олдоцын,
   - Гүний усны,
   - Гадаргуугийн усны ба
   - Цаг уурын судалгаа
10. ДЭЭРХ ХАЙГУУЛ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД ЦУГЛУУЛСАН БҮХ ӨГӨГДЛҮҮД
11. ЭДГЭЭР ӨГӨГДӨЛ БОЛОН БУСАД МАТЕРИАЛЫН СУУРИН БОЛОВСРУУЛАЛТ БА ТАЙЛАН (хураангуй байдлаар)
    - Налуугийн тогтвортой байдал,
    - Хуучин далангийн хөрсний даацын талаарх дэлгэрэнгүй дүгнэлт,
    - Хөрсний суулт,
    - Мөнх цэвдэг,
    - Хөнгөн жинтэй дүүргэгч,
    - Тохиромжгүй хөрс ба материал,
    - Далангийн хөрс ба чулуулаг,
    - ... гм.
    - Тэдгээрийн туршилт, шинжилгээний үр дүн,
    - Эдгээрт үндэслэсэн дүгнэлт.
12. ГЕОДЕЗИЙН ХЭМЖИЛТ
13. ГЕОДЕЗИЙН ХЭМЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН СУУРИН БОЛОВСРУУЛАЛТ БА ТАЙЛАН (хураангуй байдлаар)
14. ТӨСӨЛЛӨЛТӨД АШИГЛАСАН БНбД БОЛОН СТАНДАРТУУД
15. ГЕОМЕТР ХЭМЖЭЭСИЙГ ТӨСӨЛЛӨХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД
    - Ерөнхий шаардлага,
    - Босоо муруй,
    - Цэвэр зай хэмжээний шаардлага,
    - Онгон, амьд байгальд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ,
    - ... гм

Хүснэгт 11.1 Төсөллөлтийн шалгуур үзүүлэлтүүд ба БНбД

Шалгуур үзүүлэлтийн нэр, төрөл	НбД болон стандартын заалт	Норм ба дүрмийн заалтыг хангасан, эсэх талаарх тайлбар
ЗАМЫН ТӨСӨЛЛӨЛТ		
Төсөллөлтөд мөрдөх НбД болон стандартууд: ЗЗББНбД		
ХЭВТЭЭ ЧИГТ		
Тооцоот хурд		
Муруйн тохиромжтой радиус		
Муруйн хамгийн бага радиус		
Үзэгдэх хамгийн бага зай		
Гүйцэж түрүүлэх үеийн үзэгдэх хамгийн бага зай		
БОСОО ЧИГТ		
Зогсох үеийн үзэгдэх хамгийн бага зай		
Шийдвэр гаргах үеийн үзэгдэх хамгийн бага зай		
Гүйцэж түрүүлэх үеийн үзэгдэх хамгийн бага зай		
Хотгор муруйн тохиромжтой радиус		
Хотгор муруйн хамгийн бага радиус		
Гүдгэр муруйн тохиромжтой радиус		
Гүдгэр муруйн хамгийн бага радиус		
Босоо муруйн хамгийн их урт		
Хамгийн их налуу		
ХӨНДЛӨН ОГТЛОЛД		
Замын эцсийн өргөн		Төмөр хашилт суулгах бол тэр хэсэгт замын өргөнийг 2 талд нь тус бүр 1м-ээр өргөсгөнө гм,
Зорчих хэсгийн хөндлөн налуу		
Хөвөөний нийт өргөн (үүнд бэхэлгээтэй нь)		
Өндөрлөсөн далангийн хажуу налуугийн харьцаа		
Ухмалын хажуу налуугийн харьцаа		

Замын төмөр хашилт суулгах нөхцөл ба шаардлага		

16. БҮТЭЭЦИЙН ТӨСӨЛЛӨЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- Ерөнхий шаардлага,
- Зөвшөөрөх боломжтой бүтээгдэхүүн,
- Зөвшөөрөх боломжгүй материал ба хийц,
- Шинэ бүтээцүүд,
- … гм

Хүснэгт 12.1 Бүтээцийн төсөллөлтийн шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлтийн нэр, төрөл	**НбД болон стандартын заалт**	**Норм ба дүрмийн заалтыг хангасан, эсэх талаарх тайлбар**
ГҮҮР БА ХООЛОЙНЫ ТӨСӨЛЛӨЛТ		
Төсөллөлтөд мөрдөх НбД болон стандартууд: ЗЗББНбД ….		
ХООЛОЙ (1500мм ба түүнээс дээш диаметртэй дугуй, мөн дөрвөлжин хоолойнууд)		
Төрөл		Эдийн засгийн үр ашиг талаас нь атриат гадаргуутай төмөр хоолойг зөвшөөрөхгүй
Шороон хучлагын хамгийн бага зузаан		
Замын цэвэр өргөн		Төмөр хашилттай хэсэгт 2 хашилтын хоорондох цэвэр зай
Дэвсгэр үеийн хэвгий		
Гидроинженерийн нөхцөл		Ж-нь: хийц нь 100 жилд 1 тохиох үерт төсөллөгдсөн байх
Хиймэл байгууламжийн ул хөрс		Тохиромжгүй хөрс солих гм
Х/Б-ийг буцааж булах		Буцааж булахдаа заавал элс хэрэглэнэ
Захын хэсгүүдийн налуу, бэхэлгээ ба хамгаалалт		
Угаагдлаас хамгаалах		
Зэврэлтээс хамгаалах		
ГҮҮР		
Тооцоот ачаалал		
Ангилал		
Зорчих хэсгийн цэвэр өргөн		Дугуй цохигчдын хоорондох

Дамжих хавтан		
Хөдөлгөөний урсгалын тоо		
Геометр хэмжээс		Ташуу байдал нь ... градусаас ихгүй байна
Гидроинженерийн үзүүлэлт		Ж-нь: Их усны хамгийн дээд түвшин ба хийц нь 100 жилд 1 тохиох үерт төсөллөгдсөн байх

17. УС ЗАЙЛУУЛАХ БУСАД БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨЛЛӨЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД
    - Төсөллөлтийн ерөнхий шаардлага,
    - Төрөл бүрийн шуудуу,
    - Бүх хоолойг 50 жилийн ашиглалтын хугацаагаар төсөллөх,
    - ... гм
18. НАРИЙВЧИЛСАН ТӨСӨЛЛӨЛТ
    - Байр зүйн зургийн,
    - Дэвсгэр зургийн,
    - Дагуу огтлолын,
    - Хөндлөн огтлолын,
    - Хучилтын хийцийн,
    - Гүүр ба хоолойны,
    - Ус зайлуулах жижиг байгууламжийн,
    - Замын тоноглолын,
    - ... гм.
19. ЗАМЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ БА ДҮГНЭЛТ
20. ХӨДӨЛГӨӨНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
21. ЗАМЫН ТЭМДЭГ БА ТОНОГЛОЛЫН ТӨСӨЛЛӨЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД
22. ЗУРГИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕРИЙН ШИЙДЛҮҮД
    - Анхны төсөөлөл, загвар
    - Хэрэглэсэн арга,
    - Бүрдэл хэсгүүдийн геометр хэмжээсийн,
    - Дэвсгэр зургийн,
    - Дагуу огтлолын,
    - Хөндлөн огтлолын,
    - Хиймэл байгууламжийн,
    - ... төсөллөлт гм.
23. ХОЛБОГДОХ ТООЦООНУУД
    - Хөдөлгөөний эрчмийн,
    - Усны зарцуулалтын,
    - Хучилтын,
    - Хийцийн,
    - Хэсгүүдийн,
    - ... гм.
24. ТУРШИЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН
25. БАЙГАЛИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЛААР

26. ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ (ИНЗ)-ИЙГ ХЭРХЭН БОЛОВСРУУЛСАН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ТАЙЛБАР
27. БОЛОВСРУУЛАЛТЫН ДУНД ШАТАНД ХЯНАЖ ДҮГНЭСЭН БА ЗАХИАЛАГЧААС ГАРГАСАН НЭМЭЛТ САНАЛЫГ ТУСГАСАН ТАЛААР
28. ЗУРАГ ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАЛТЫН ТӨГСГӨЛИЙН ШАТАНД ХЯНАЖ ДҮГНЭХ
29. ЗУРАГ ТӨСЛИЙГ ЭЦЭСЛЭН ХЯНАХ
30. ЗУРАГ ТӨСЛИЙГ ЭКСПЕРТИЗЕД ОРУУЛЖ, ХЯНУУЛАХ.

Бэлтгэж, танилцуулах тайлан

Зөвлөх нь ИНЗ-ийг боловсруулах үйл ажиллагааныхаа тодорхой үе шатанд гүйцэтгэсэн ажлуудын явц, чанар, үр дүн, амжилт, алдаа дутагдал, тохиосон саад бэрхшээл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний холбогдолтой асуудлыг тусгасан дараах тайлангуудыг дэлгэрэнгүй байдлаар бэлтгэж, доорх хуваарийн дагуу Захиалагчид хүргүүлнэ. Үүнд:

Эхний тайлан

Эхний тайланд тухайн замд хийсэн төрөл бүрийн судалгааны, мөн тэдгээртэй холбогдуулан хийх туршилтыг багтаасан өгөгдөл цуглуулах ба боловсруулах ажлын төлөвлөгөө, улмаар түүний дагуу гүйцэтгэж эхэлсэн ажлуудын явц, эхний үе шатанд үүссэн нөхцөл байдал, саад бэрхшээл, яаралтай шийдвэрлэх шаардлагатай асуудлууд, Талуудаас авбал зохих арга хэмжээ зэргийг тусгах ба гэхдээ эдгээрээр зөвхөн хязгаарлагдах ёсгүй.

Завсрын тайлан

Энэ тайланд замын трассын өөрчлөлт, төрөл бүрийн хайгуул, судалгааны эцсийн үр дүн, замын үндсэн элементүүд болон гүүр, хоолойны төсөллөлтийн шалгуур үзүүлэлтүүдийн сонголт ба тохиромжтой байдлын үнэлгээ, дэвсгэр зураг, дагуу ба хөндлөн огтлол, хучилтын хийц зэрэг үндсэн хэсгүүдийн холбогдох тооцоо ба нарийвчилсан төсөллөлтийн явц, цаашид хийх ажлын талаар дэлгэрэнгүй тусгасан байна.

Инженерийн дэлгэрэнгүй тайлан

Тухайн замын ИНЗ-ийг боловсруулж, бүрэн дуусаны эцэст Зөвлөх энэхүү тайланг доор хавсралт № 1-д үзүүлсэн жишиг бүтцийн дагуу, баримт бичгийн иж бүрдлийг сайтар ханган, чанартай боловсруулж танилцуулна.

ИНЗ-тай холбогдолтой тайланг танилцуулах хуваарь

№	Тайлангийн төрөл	Танилцуулах хугацаа
1	ИНЗ боловсруулах үйл ажиллагааны Эхний тайлан (ЭТ)	ЗҮ-ний гэрээнд заасан ИНЗ боловсруулах ажлын эхлэх огнооноос хойш хуанлийн 1 сарын дотор
2	Инженерийн зургийн үндсэн хэсгүүдийн нарийвчилсан төсөллөлтийн асуудлыг тусгасан явцын буюу Завсрын тайлан (ЗТ)	ИНЗ боловсруулах ажлын эхлэх огнооноос хойш хуанлийн … сарын дотор
3	Инженерийн дэлгэрэнгүй тайлан (ИДТ)	ИНЗ боловсруулах ажлын эхлэх огнооноос хойш хуанлийн … сарын дотор
4	Байр зүйн судалгааны болон геодезийн хэмжилтийн ажлын дэлгэрэнгүй тайлан,	ИНЗ-тай хамт
5	Геоморфолог, гидрогеолог, геотехникийн болон материалын олдоцын судалгааны дэлгэрэнгүй тайлан	ИНЗ-тай хамт
6	Гадаргуугийн усны ба цаг уурын судалгааны дэлгэрэнгүй тайлан	ИНЗ-тай хамт